

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Албаны үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Баян-Өндөр цэцэрлэг”, Үйлбадрах ӨЭМТөв, “Хотын захирагчийн алба”-ны болзошгүй аваарын зардал, “Гэр бүлийн ордон”, Баян-Өндөр сум ЗДТГ-ын болзошгүй аваарын зардал, Жаргалант сум ЗДТГ-ын болзошгүй аваарын зардал зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

“Хот байгуулалт, барилга захиалагч”-ийн алба, Эрдэнэ цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа, “Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар”, Жаргалант сумын “Жаргалант ус дулааны станц” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын 2024 оны 4 дүгээр улирлын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд дотоод аудитыг гүйцэтгэлээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 99%-тай дүгнэгдсэн. Дотоод аудитын тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос албан хаагчдын дунд “Ээж, хүү/охин” спортын өдөрлөгийг 2025.02.20-ны өдөр зохион байгуулж ажиллалаа.




Төрийн албаны зөвлөлөөс ирсэн үүрэг чиглэлийн дагуу “ХНУМТ-ийн цахим системд 10 албан хаагчдын анкет баталгаажуулах ажлыг зохион байгуулсан.

2025.02.26-ны өдөр Байгууллагын хариуцсан талбайд бүх албан хаагчид цэвэрлэгээ хийлээ.



2. Сургалт, зөвлөгөөн

- 2025.02.07-ны өдөр “Насан туршийн суралцахуй төв”-тэй хамтарсан “Үндэсний бичгийн зөв бичгийн дүрэм”, “Бусдын эрх ашгийг хүндэтгэн хамтран ажиллах” сэдэвт дотоод сургалтуудыг зохион байгуулсан.




- 2025.02.13-ны өдөр “Насан туршийн суралцахуй төв”-тэй хамтарсан “Бусдыг мэдэрч ойлгох” сэдэвт сургалтыг багш С.Алтанцэцэг, “Өөрийн насан туршдаа суралцахуйд свот хийх” сэдэвт сургалтыг багш Н.Лхагвадулам нар зааж, дотоод сургалтыг зохион байгуулсан.



- 2025.02.19-ний өдөр “Эрүүл мэндийн газар”-тай хамтарсан “Хүний нөөцийн тогтвортой байдал, ажлын байран дахь сэтгэл ханамж, ажлаас халшрах хам шинж, түүнийг тодорхойлох, даван туулах” сэдэвт дотоод сургалтыг зохион байгуулсан.



- 2025.02.20-ны өдөр Төрийн албаны зөвлөл Орхон аймагт ажиллах үеэр зохион байгуулсан сургалтад байгууллагын бүх албан хаагчид танхимаар болон цахимаар сургалтад хамрагдлаа.



- 2025.02.25-ны өдөр Улсын Их хурлын гишүүн Б.Баярбаатараар ахлуулсан ажлын хэсэг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг боловсронгуй болгох асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, хуулийн төсөл боловсруулах” хэлэлцүүлэгт Газрын дарга, ХШҮХМэргэжилтэн, Нярав нар оролцлоо.



3. Үүрэг даалгаврын биелэлт:

- Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр 2025.02.05-ны өдөр Захиргааны III байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудад ажиллах үеэр албаны дарга байгууллагын 2025-2028 онд хийж хэрэгжүүлэх ажлын зорилго, зорилт, 2024 онд хийж хэрэгжүүлсэн онцлох ажил, албан хаагчдад тулгамдсан асуудлыг танилцуулж ажиллалаа.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР